



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/1/СТА-ТЭЗ

Цахим хуудас: www.audit.mn	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Должмаа Утас: 88119345 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn Аудитор: Н.Бунчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: nbunchin0719@gmail.com Аудитор: Г.Ганчимэг Утас: 88268424 Цахим хаяг: ganaa_7133@yahoo.com
Баянхонгор хот 2020 он	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	8
2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт.....	11
2.8.3 Авлага.....	11
2.8.4 Урьдчилгаа.....	13
2.8.5 Бараа материал	14
2.8.6 Үндсэн хөрөнгө.....	15
2.8.7 Урт хугацаат хөрөнгө оруулалт.....	16
2.8.8 Өр төлбөр	17
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	19
ТӨҮГ болон ОНӨҮГ хувьд эздийн өмч дансанд гарсан өөрчлөлт	19
2.9. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	20
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	27
2.11. Шилэн дансны мэдээлэл	27
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	27
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	28
2.14. Менежментийн захидал.....	29
3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	31
3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	31
3.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	33
3.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	36
3.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	40
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	40
3.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	44
4. Хавсралт судалгаа.....	47-80
5.Зөрчлийн нэгтгэл.....	81-82

Товчилсон үгийн жагсаалт

АОУС,	Аудитын олон улсын стандарт
АДБОУС,	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС,	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС,	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
СХАА,	Санхүүгийн хяналт аудитын алба
СТХС	Санхүү Төрийн сангийн хэлтэс
СХСан	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЦТ	Цахилгаан түгээх
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани
ХК	Хувьцаат компани
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн тэргүүлэгчдийн хурал
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар

Хавсралт

Хавсралт №1	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт
Хавсралт №2	Баянхонгор аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 2019 оны нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар тогтоосон төлбөрийн актын нэгтгэл
Хавсралт №3	Баянхонгор аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар хүргүүлсэн төлбөрийн албан шаардлагын нэгтгэл
Хавсралт №4	Баянхонгор аймгийн төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримтын бичгийн судалгаа
Хавсралт №2	Төлбөр зөрчлийн жагсаалт

1. Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ Г
ДАРГА ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧ Г.БАТЖАРГАЛ ТАНАА Г

2020.04.20 № 1/401
танай _____ -ны № _____ -г

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод

• 005020334

**Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит**


хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Баянхонгор аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дугаар зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Г.Батжаргалд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 04 дүгээр сарын 05-аас 2020 оны 04 дүгээр сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа, аудитор Г.Ганчимэг, Н.Бүнчинсүрэн нар гүйцэтгэв.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймгийн Төрийн аудитын газарт Баянхонгор аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 06-ний өдрийн 1а/221 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор аймгийн Засаг дарга нь “Бүтээх чадвартай өндөр мэргэшсэн ажиллах хүчнээр хангагдсан, унаган байгаль экологийн тэнцвэрийг хадгалж, байгаль орчныхоо онцлогт зохицсон, экспортод чиглэсэн үйлдвэрлэл үйлчилгээ хөгжсөн, хүний болон эдийн засгийн хөгжлөөрөө Монгол Улсын тэргүүлэх аймгуудын нэг болох” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Баянхонгор аймгийн Засаг даргын үйл ажиллагааны чиглэлийг 2019 онд дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд хамгаалал өв тэгш хүмүүжлийн жил
- Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх дадлагажуулах тэдний нийгмийн баталгааг ханган ажиллана.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2018 оны 182 дугаар “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл, суурь үнэлгээ, гарын төлбөрийн хэмжээг тогтоох тухай” тогтоол гарч, газрын төлбөрийг ИТХ-аар шинэчлэн тогтоосон.
- Тусгай зориулалтын шилжүүлгийн бүрэлдэхүүнд багтдаг 19 сумын соёлын төв, аймгийн төвийн Биеийн тамир спортын салбар, Түүх угсаатны зүйн музей, Нийтийн номын сан, Хөгжимт драмын театр, Хүүхдийн Тэмүжин театр зэрэг байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлыг орон нутгийн суурь зарлагад шилжүүлсэн. Үүнтэй холбоотойгоор нэмэлт орлогын зарцуулалтын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, нэмэлт орлогыг зарцуулах журмыг баталж мөрдсөн.
- Соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааны орлогыг 2019 онд батлахгүй байхаар тооцож, уран бүтээл туурвиж олсон орлогоо соёл урлагийн салбарын ажилтнуудын нийгмийн баталгааг хангах, цалин урамшуулал, уран бүтээл туурвих зэрэг бусад шаардлагатай зардалд бие даан зарцуулахаар шийдвэрлэсэн.
- Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны дагуу өмчийн ашиглалт, хамгаалалт, үр ашгийг сайжруулах зорилгоор сургууль, цэцэрлэг, эмнэлгийн байр ашиглалттай холбоотой зардлыг орон нутагт хариуцуулсан.
- Дотоод албан томилолтын зардлын тарифыг Сангийн сайдын тушаалаар шинэчлэн нэмэгдүүлэн баталсан.
- Өмчийн ашиглалт хамгаалалт, бүртгэлийг сайжруулах зорилгоор сумын санхүүгийн албанаас сургууль, цэцэрлэг, эмнэлгийн нягтлан бодогч нарыг тухайн байгууллагад нь шилжүүлэн ажиллуулах зохицуулалт хийсэн.
- Баяр наадам тэмдэглэх, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах гэх мэт урьдчилан төлөвлөх боломжтой зардлыг нөөц хөрөнгөөс санхүүжүүлдэг байсныг өөрчлөн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тооцож шаардагдах зардлын хэмжээг нэмэгдүүлсэн.
- Агаарын бохирдлын төлбөрийн орлого болон газрын тосны тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос орон нутгийн төсөв үлдэх хэсгийг тухайн орон нутгийн байгаль орчныг хамгаалах, ойжуулах, усжуулах, хүрээлэн буй орчныг нөхөн сэргээхэд

зарцуулах ба цаашид агаар, орчны бохирдлыг бууруулах чиг үүргийг бие даан хэрэгжүүлэх боломжийг орон нутагт олгосон.

- Хог хаягдлын хураамжийг сумын орлогын төлөвлөгөөнд тусгаж, хувь хэмжээг сумын ИТХ-аар шинэчлэн батлуулсан.
- Байнгын давтамжтай нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээг өрхийн мэдээллийн санг түшиглэн улсын төсвөөс шууд олгохоор шийдвэрлэсэн.
- Эрчим хүчний сайдын 2017.09.05-ны өдрийн 112 дугаар тушаалын 16 дэх заалтыг үндэслэн халаалтын эхлэх хугацааг тухайн оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөр, дуусах хугацааг дараа оны 05 дугаар сарын 15-ны өдрөөр өөрчлөн, аймгийн хангайн 10 сумдад 8 сараар, Шинэжинст, Баян-Өндөр сумдад 7.5 сараар баталсан байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монгол Улсын Ерөнхий аудитораас өгсөн чиглэлийн дагуу төсөвт байгууллагуудад ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн /цаашид НБББББ гэх/ судалгааг нэгтгэж үзвэл нийт байгууллагын 54.8 хувь нь НБББББ-ийг боловсруулж мөрдсөн, 45.2 хувь нь НБББББ-гүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2¹ дахь заалтыг зөрчсөн байна.

Боловсруулсан НБББББ-ийн талаар судлахад 2016 онд Сангийн яамнаас ирсэн ажлын хэсэг, СХАА, СТХС-ийн хамтран боловсруулсан “Төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг үйл ажиллагаанд мөрдөж байсан ба дээрх жишиг баримт бичигт үндэслэн 2018 онд аймгийн СТХС-ээс зохион байгуулсан “Мэргэжсэн нягтлан бодогч аян”-ы хүрээнд төсөвт байгууллагуудын нягтлан бодогчид байгууллагын онцлог, үйл ажиллагаанд уялдуулж НБББББ-ийг боловсруулан мөрдөж байгаа боловч аудитаар хийсэн судалгаагаар одоогийн мөрдөж байгаа НБББББ-ийг шинэчлэн боловсруулах шаардлагатай гэж нягтлан бодогчдын 61.9 хувь нь үзсэн байна. Иймд байгууллагын үйл ажиллагааны онцлогтой уялдуулж, хууль, журамтай нийцүүлэн санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх НБББББ-ийг шинэчлэн боловсруулж, арга зүйгээр хангаж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Баянхонгор аймгийн Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Санхүүгийн хяналт, аудитын алба 2019 онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт 97, төлөвлөгөөт бус 4, нийт 101 хяналт шалгалт хийж, аудитаар нийт 254.2 сая төгрөгийн зөрчилд 134 төлбөрийн акт тогтоож, 152.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 101.5 сая төгрөгийг тухайн шалгагдагч байгууллагын дансанд оруулахаар шийдвэрлэсэн бөгөөд актын биелэлт 82.3 хувьтай байна.

Хяналт шалгалтаар 6 улсын байцаагчийн 6 албан шаардлагаар 108.5 сая төгрөгийн хохирол тооцож тухайн байгууллагын дансанд оруулахаар шийдвэрлэснийг бүрэн биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын аймгийн Засаг даргатай 2019 онд байгуулсан үр дүнгийн гэрээ “Хангалттай” гэж дүгнэгдсэн байна.

¹ Аж ахуйн нээж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.

Аймгийн Засаг даргаар ахлуулсан 8 хүний бүрэлдэхүүнтэй Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын хороо 2019 онд 2 удаагийн хуралдаанаар 14 асуудлыг хэлэлцэж, 4 тогтоол гаргаж холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл, зөвлөмж өгч ажилласан байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянхонгор аймгийн Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг аудитор гүйцэтгэлээ.

Баянхонгор аймгийн Засаг дарга санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Засгийн газрын санхүүгийн "Э-тайлан", төсвийн төлөвлөлтийн Piscal программ хангамж ашигладаг байна.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 17 дунд эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 15 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэн 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 114107.6 сая төгрөгийн 0.5 хувь буюу 570.5 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 128295.7 сая төгрөгийн 0.5 хувь буюу 641.4 сая төгрөгөөр тооцсон бөгөөд төлөвлөлтийн шатанд тооцсон материаллаг байдлаас 70.9 сая төгрөгөөр өссөн нь төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс тооцсонтой холбоотой байна.

2.8 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 4952.6 сая, эцсийн үлдэгдэл 7843.8 сая төгрөг болж, 2891.2 сая төгрөгөөр буюу 58.3 хувиар өссөн байна. Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 6733.6 сая буюу 85.8 хувь нь касс болон төрийн сангийн харилцах дансанд, 1110.1 сая буюу 14.2 хувь нь арилжааны банканд байршиж байна.

**Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Хүснэгт 1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Банканд байгаа бэлэн мөнгө		Өсөлт (+), Бууралт (-)
				Арилжааны банк	Төрийн сангийн нэгдсэн данс	
Кассад байгаа бэлэн мөнгө	2.6	2.7	2.7			0.1
Төгрөг/ ЖМС	2.6	2.7	2.7			0.1
Нэмэлт санхүүжилтийн						0
Касс						0
Банканд байгаа бэлэн мөнгө	4950.0	7841.1	0.0	1110.1	6731.0	2891.1
Төгрөг	4950.0	7,841.1		1110.1	6,731.0	2891.1
Гадаад валют	0.0	0				0
Замд яваа мөнгөн хөрөнгө	0.0	0				0
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	4952.6	7843.8	2.7	1110.1	6731.0	2891.2
<i>Үүнээс байгууллагын төрлөөр:</i>						
Төрийн сан	1241.7	2400.4		0.03	2400.4	1158.7
Төсөвт байгууллагууд	2,593.8	1,977.1		0.2	1976.9	-616.7
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	602.3	1037.6	2.7	1034.9		435.3
Төсөл, сангууд	514.8	2428.7		75.0	2353.7	1913.9

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

1. Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгө оны эхэнд 1241.6 сая төгрөг байснаас оны эцэст 2400.3 сая төгрөг болж өмнөх оноос 1158.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Төрийн сангийн ерөнхий орлогын данс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс		Өсөлт (+), Бууралт (-)
			Орон нутгийн орлого	Буцаан төвлөрүүлэлт	
Баянхонгор аймаг	154.9	1,302.4	1265.2	37.2	1147.5
Галуут	6.5	44.4	40.1	4.2	37.8
Баян-овоо	0.3	36.6	32.3	4.3	36.3
Эрдэнэцогт	6.4	17.3	11.1	6.3	10.9
Бууцагаан	39.6	23.0	15.4	7.6	-16.5
Жинст	17.5	43.8	25.1	18.7	26.3
Богд	47.8	22.1	16.1	6.0	-25.7
Баянлиг	30.8	27.7	19.3	8.4	-3.1
Баянговь	59.1	51.9	46.7	5.2	-7.2
Гурванбулаг	6.6	54.6	29.8	24.8	48.0
Жаргалант	12.2	32.8	30.0	2.8	20.6
Заг	23.7	39.9	23.4	16.5	16.1
Баацагаан	30.5	26.8	24.9	1.9	-3.7
Бөмбөгөр	10.1	24.1	22.8	1.3	14.0
Өлзийт	18.0	56.4	55.3	1.0	38.4
Хүрээмарал	6.4	82.4	74.3	8.1	76.0
Баянбулаг	86.2	27.5	19.9	7.6	-58.7
Шинэжинст	52.1	78.5	29.3	49.2	26.4
Баянцагаан	64.4	68.4	65.1	3.3	4.0
Баян-өндөр	73.9	104.3	71.5	32.8	30.5
Баянхонгор	494.8	235.6	232.3	3.3	-259.2
Нийт дүн	1,241.6	2,400.3	2149.8	250.5	1158.7

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн эхний үлдэгдлээс тайлант онд 371.0 сая төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсвийн орлого 12059.9 сая төгрөг бүрдүүлж, 10901.2 сая төгрөгийг харьяа байгууллагуудын урсгал санхүүжилтэд зарцуулжээ.

Тайлант оны эцэст төсвийн ерөнхий орлогын данс 2400.3 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээс 1097.9 сая төгрөг нь 20 сумын орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл бөгөөд оны эцэст аймгийн төвийн төсөвт байгууллагууд зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлснээс 37.2 сая, төлөвлөгөөнөөс давсан орлогын 1265.2 сая, нийт 1302.4 сая төгрөг аймгийн орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдлээр байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулаагүй үлдэгдлийг оны эцэст орон нутгийн орлогод 243.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байхад авлага, өглөгөөр тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4², 14 дүгээр зүйлийн 14.4.2³-т заасантай нийцэхгүй байгаа тул цаашид авлага, өглөгийг тухай бүр санхүүгийн тайланд тусгаж байх зөвлөмжийг хүргүүлэв.

2. Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгө:

Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 2593.8 сая, эцсийн үлдэгдэл 1977.1 сая төгрөг болж, өмнөх оноос 616.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Сумын нэр	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		Сумын нэр	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл			
	СХСан	ОНХСан		СХСан	ОНХСан	Замын сан	Өрхийн эмнэлгүүд
Галуут	83.3	59.8	Баацагаан	12.6	60.1		
Баян-Овоо	0.0	0.0	Бөмбөгөр	5.9	77.0		
Эрдэнэцогт	54.6	130.3	Өлзийт	74.2	39.1		
Бууцагаан	5.9	38.4	Хүрээмарал	34.7	32.5		
Жинст	6.8	16.8	Баянбулаг	49.7	49.5		
Богд	15.9	2.7	Шинэжинст	159.5	13.3		
Баянлиг	70.4	73.8	Баянцагаан	95.3	2.2		
Баянговь	111.8	1.8	Баян-Өндөр	34.5	29.0		
Гурванбулаг	54.5	6.1	Баянхонгор сум	116.3	39.2		
Жаргалант	57.8	62.6	Аймгийн ОНХС		0.4		
Заг	59.5	118.5	Аймаг			20.7	0.2
	Нийт дүн			1103.0	853.2	20.7	0.2

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3. Төсөл сангийн мөнгөн хөрөнгө:

Төсөл сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 1913.9 сая төгрөгөөр өсөж, 2428.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагийн 1601.8 сая төгрөг нь улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээнээс тооцсон барьцаа, 503.4 сая төгрөг нь ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжийн Барилгын тухай хуульд заасан баталгаат хугацааны барьцаа, 75.0 сая төгрөг нь Хас банканд жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор байршуулсан мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

Хүснэгт 4 Төсөл сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Орон нутгийн нөөц сан	208.9	243.2	34.3
Техник хяналт данс	218.9	1601.8	1382.9
Барьцаа хөрөнгийн данс	0.0	503.4	503.4
Хөрөнгө оруулалтын барьцаа данс /Хас банканд байршуулсан-ЖДҮ/	87.0	75.0	-12.0
Байгал хамгаалах зардал	0.0	5.3	5.3
Нийт дүн	514.8	2428.7	1913.9

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

4. Арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгө:

Арилжааны банканд байршиж байгаа мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 690.5 сая, эцсийн үлдэгдэл 1110.1 сая төгрөг болж, 419.6 сая төгрөгөөр өссөн бөгөөд үлдэгдлийн 93.2 хувийг ТӨҮГ болон ОНӨААН-ийн үлдэгдэл, 6.7 хувийг төсөл сангийн үлдэгдэл, 0.002 хувийг төсөвт байгууллага эзэлж байна.

² "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна"

³ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

**Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Хүснэгт 5. Арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төсөвт байгууллага	3.3	0.2	-3.1
Төсөл/ сан	87.0	75.0	-12.0
Төрийн сан	0.03	0.03	0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	600.1	1034.9	434.8
Дүн	690.5	1110.1	419.6

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТӨҮГ болон ОНӨҮГ-ийн харилцах дансны үлдэгдэл 1034.9 мянган төгрөг байгаагаас “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн харилцах дансны үлдэгдэл 734.4 сая, “Чандмань Баянхонгор” ХК-ийн үлдэгдэл 139.9 сая, Баянхонгор Үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн үлдэгдэл 76.4 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

Баянговь сумын төрийн сангийн арилжааны банкин дахь үлдэгдэл өмнөх онд 0.03 сая төгрөг байсан нь тайлант онд өөрчлөлт ороогүй, үлдэгдлээр байгаа тул дансыг хаах арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг хүргүүлэв.

2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Баянхонгор аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд богино хугацаат хөрөнгө оруулалт байхгүй.

2.8.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 5902.0 сая, эцсийн үлдэгдэл 7497.4 сая төгрөг болж, 1595.3 сая төгрөгөөр өссөн бөгөөд нийт авлагын 75.4 хувийг сум хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн сан, болон жижиг дунд үйлдвэрлэлт олгосон зээлүүд эзэлж байна.

Хүснэгт 6. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	28.5	21.4	-7.2
Төлбөртэй үйлчилгээний авлага	105.8	110.4	4.6
Татаас, санхүүжилтийн авлага	0.0	0.0	0.0
Зээлийн хүүгийн авлага	0.0	0.0	0.0
Дансны авлага /ТӨҮГ/	0.1	0.6	0.6
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	0.9	0.9	0.0
Бусад авлага	1052.1	2313.0	1260.9
Зээлийн авлага	4714.6	5051.0	336.4
Дүн	5902.0	7497.4	1595.3
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	4519.3	5491.7	972.4
Төсөл/ сан	180.0	714.5	534.5
Төрийн сан	0.0	0.0	0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	1202.8	1291.2	88.4
Дүн	5902.0	7497.4	1595.3

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жил болсон 855.6 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-аар дамжуулан олгосон хугацаа хэтэрсэн зээлийн 219.6 сая төгрөгийн авлага;
- Аймгийн ОНХС-аас өмнөх онуудад жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгосон хугацаа хэтэрсэн зээлийн 475.9 сая төгрөгийн авлага;
- “Хонгор шинэ агро” ОНӨААТҮГ-ийн 2017 онд иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, сумдад олгосон өвс, тэжээлийн 90.9 сая төгрөгийн авлага;

- Гурванбулаг сумын Иргэдийн төлөөлөгчийн хурлын даргаар ажиллаж байсан Цэдэндамбаатай холбоотой 3.0 сая төгрөгийн авлага;
- “Хайрхан фарм” ТӨҮГ-ийн 2016 онд үүссэн 17.9 сая төгрөгийн авлага;
- Аймгийн Түүх угсаатны зүйн музейн 2008 онд үүссэн аймгийн “Цахилгаан холбоо” ТӨААН-ээс авах 1.8 сая төгрөгийн авлага барагдаагүй байна.
- “Чандмань Баянхонгор” ХК-ийн санхүүгийн тайланд 2010 оноос хойш шийдвэрлэгдээгүй Хот тохижилттой холбоотой 22.4 сая, аймгийн ЗДТГ-ын бор балгасын усжуулалтын системтэй холбоотой 11.4 сая төгрөгийн авлага барагдаагүй үлдэгдлээр байна. Энэ нь НББ-ын тухай хуулийн 20.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.8 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Олон жилийн насжилттай, хугацаа хэтэрсэн дээрх авлагууд нь тооцоо нийлсэн актгүй, олон жил болсноос эзэн холбогдогч нь тодорхойгүй болсон, аж ахуйн нэгж, байгууллага татан буугдах болон хөнгөлөлттэй зээлийг үр ашиггүй зүйлд зарцуулж, төсвийн хөрөнгийн үргүйдэх, найдваргүй авлага үүсэх сөрөг үр дагавартай тул барагдуулах арга хэмжээг авч ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

Аудитын илрүүлэлт:

- *Тайлант оны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлэхгүйгээр харилцагч байгууллагад шилжүүлснээс Бөмбөгөр сумын ЗДТГ 7.0 сая, Ерөнхий боловсролын сургууль 10.0 сая, Хүрээмарал сумын Ерөнхий боловсролын сургууль 1.6 сая, нийт 18.6 сая төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн байна.*
- *Сум хөгжүүлэх сан, аймгийн ОНХС-аас жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийн авлагыг зээлдэгч нартай тооцоог нийлж баталгаажуулаагүй, сум хөгжүүлэх сангийн программын ашиглалт хангалтгүйгээс санхүүгийн тайланд авлагыг зөрүүтэй тусгадаг зөрчил арилахгүй байна.*
- *Дээрх дурдсан олон жил болсон 8 байгууллагын 855.6. сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээг авч ажиллаагүй байна.*
- *Сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж дуусаагүй төсөл, арга хэмжээнд олгосон 836.0 сая төгрөгийн санхүүжилтийг эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгээгүй авлагаар тусгасан байна. Үүнээс зураг төсвийн үнэд 362.7 сая, хөрөнгө материал бэлтгэх урьдчилгаанд 211.8 сая, малжуулах зээлд 261.5 сая төгрөгийн олгож авлагаар бүртгэжээ.*
- *Зээлийн батлан даалтын сан аймгийн ЗДТГ-тай 2017.04.26-ний өдөр 07 тоот гэрээ байгуулж, 2017 онд орон нутгийн төсвөөс 50.0 сая төгрөг шилжүүлснийг аудитаар авлагаар залруулж бүртгүүлсэн бөгөөд аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа боловч барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй иргэд, аж ахуйн нэгжийн эрхлэгчдийн санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх зорилго бүхий тус сангаас 2019 онд 1 аж ахуйн нэгжид зээл олгож, ажлын байрыг 2-оор нэмэгдүүлсэн байна. Иймд цаашид барьцаа хөрөнгө багатай, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж, Зээлийн батлан даалтын сантай хамтарч ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.*

Сум хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийн авлагаар 2019 оны эцэст 3924.2 сая төгрөг бүртгэлтэй ба аудитын явцад хийсэн судалгаагаар нийт авлагын 42.6 хувь буюу 1672.6 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн байна. Иймд хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Сум хөгжүүлэх сангийн авлагыг судлахад Баянхонгор сум хамгийн өндөр, Шинэжинст сум хамгийн бага авлагатай байна.

**Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Хүснэгт 7. Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага /сая төгрөг/

№	Сумын нэр	Хувь хүмүүст олгосон зээлийн авлага	д.д	Сумын нэр	Хувь хүмүүст олгосон зээлийн авлага
1	Галуут	161.0	11	Заг	128.9
2	Баян-овоо	179.9	12	Баацагаан	243.1
3	Эрдэнэцогт	126.5	13	Бөмбөгөр	171.8
4	Бууцагаан	225.9	14	Өлзийт	166.5
5	Жинст	184.8	15	Хүрээмарал	157.0
6	Богд	176.1	16	Баянбулаг	152.8
7	Баянлиг	180.9	17	Шинэжинст	32.0
8	Баянговь	101.1	18	Шинэжинст	153.1
9	Гурванбулаг	138.6	19	Баян-өндөр	153.1
10	Жаргалант	191.9	20	Баянхонгор сум	899.1
					НИЙТ ДҮН 3924.2

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ОНХС-ийн санхүүгийн тайланд бүртгэлтэй нийт авлагын 25.3 хувь буюу 211.8 сая төгрөгийн авлага нь хөрөнгө, материал бэлтгэхэд олгосон урьдчилгаа байгаа тул ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгүүлж, дуусгахад хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

Хүснэгт 8. ОНХС-ийн авлага /сая төгрөг/

Сумдын нэр	ОНХС-ийн авлага	Үүнээс		Хөрөнгө, материал бэлтгэх олгосон урьдчилгаа
		Зураг төсвийн үнэ	Малжуулах зээлийн авлага	
Баянхонгор аймаг	238.5	238.5		
Баян-овоо	16.9	0.9	15.9	0.09
Эрдэнэцогт	1.6	1.6		
Богд	46.4	40		6.4
Баянлиг	20.3		10.3	10
Баянговь	50.8			50.8
Гурванбулаг	0.2			0.2
Заг	3.1		3.1	
Баацагаан	96.1		96.1	
Өлзийт	200.4	71		129.4
Хүрээмарал	78.2		76.2	2
Шинэжинст	15.7	2.7		13
Баян-өндөр	68.0	8	60	
Дүн	836.0	362.7	261.5	211.8

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.8.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 259.7 сая, эцсийн үлдэгдэл 215.5 сая төгрөг болж, өмнөх оноос 44.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	249.3	204.4	-44.9
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	9.0	9.0	0.0
Цалингийн урьдчилгаа	1.4	2.1	0.7
Томилолтын урьдчилгаа	0.0		
Дүн	259.7	215.5	-44.2
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	10.4	11.1	0.7
Төсөл/ сан	0.0	0.0	0.0
Төрийн сан	0.0	0.0	0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	249.3	204.4	-44.9
Дүн	259.7	215.5	-44.2

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансанд бүртгэгдсэн 215.5 сая төгрөгийн 204.4 сая төгрөг нь “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой бүртгэгдсэн цахилгааны урьдчилгаа төлбөрийн орлого ба 9.0 сая төгрөг нь 2018 онд үүссэн Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэгийн агуулахын барилгатай холбоотой гарсан зардлыг бүртгэсэн авлага ба ажлыг одоо хүртэл дуусгаагүй байна.

2.8.5 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 6577.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 8741.3 сая төгрөг болж, 32.9 хувиар буюу 2163.7 сая төгрөгөөр өссөн нь эргэлтийн хөрөнгөнд дуусаагүй хөрөнгө оруулалтын ажиллагаа болон хөрөнгийг бүртгэсэнтэй холбоотой байна. Мөн нөөцийн барааны эхний үлдэгдэл 1930.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 1749.5 болж 159.7 сая төгрөгөөр буурсан нь бараа материалын дансанд шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 10. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Бараа материалын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	1,155.4	1,435.3	279.9
Эм боох материал	10.8	53.6	42.8
Дуусаагүй үйлдвэрлэл	86.6	436.1	349.5
Бэлэн бүтээгдэхүүн	38.2	29.4	-8.8
Бичиг хэргийн материал	160.9	202.7	41.8
Аж ахуйн материал	2,921.7	3,182.2	260.5
Сэлбэг хэрэгсэл	33.4	27.1	-6.3
Түлш шатахуун, тослох материал	50.3	51.3	1.0
Барилга засварын материал	37.8	133.5	95.7
Хүнсний материал	68.8	112.7	43.9
Бусад хангамжийн материал	1,757.8	2,818.7	1060.9
Мал амьтад	256.0	258.7	2.7
Бараа материалын дүн	6577.6	8741.3	2163.7
Нөөцийн бараа	1,930.5	1,770.8	-159.7
НИЙТ ДҮН	8,508.1	10,512.1	2,004.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст төсөвт байгууллагууд 112.6 сая төгрөгийн хүнсний материал, 95.7 сая төгрөгийн барилгын засварын материал, 42.8 сая төгрөгийн эм боох материал, нийт 251.3 сая төгрөгийн бараа материалыг нөөцөлсөн байна. Энэ нь сургууль, цэцэрлэгүүд оны эцэст төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүй, засварын материал, хүнсний материалыг худалдан авсан, аймгийн төвийн ахлах сургуулиудад шүдний тоног төхөөрөмжийн хамт бодис урвалж, сумдын Эрүүл мэндийн төвүүдэд урьдчилан сэргийлэх үзлэгийн сорилын тестийг олгосон зэрэгтэй холбоотой байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа, ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 421.4 сая төгрөгийн хөрөнгө дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй байгаагаас Баянлиг, Баянцагаан сумын өмнөх онд бүртгэсэн 79.2 сая төгрөгийн ажил хийгдэж дуусаагүйгээс дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй хэвээр байна.

Нийт бараа материалын үлдэгдлийн 91.9 хувийг төсөвт байгууллага, 8.1 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бараа материал тус тус эзэлж байна.

**Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Хүснэгт 11. Бараа материалын хөдлөл өөрчлөлт /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Эхний үлдэгдэл	6600.9	8508.1	1907.2
<i>Нэмэгдсэн</i>	13048.9	14779.0	1730.1
Худалдан авсан	11255.5	13128.2	1872.7
Хандиваар	1107.2	429.2	-678.0
Шилжүүлэн авсан	257.5	872.8	615.3
Шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр	17.6	2.3	-15.3
Бусад	411.1	346.5	-64.6
<i>Хасагдсан</i>	11141.7	12774.9	1633.3
Худалдсан, зарцуулсан	10857.7	10185.8	-671.9
Шилжүүлсэн	41.3	1260.3	1219.0
Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр	3.0	902.1	899.0
Бусад	239.6	426.8	187.1
Эцсийн үлдэгдэл	8508.1	10512.1	2004.0
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	7533.4	9660.7	2127.3
Төсөл/ сан			0
Төрийн сан			0
ТӨҮГ болон ОНӨҮГ	974.7	851.4	-123.3
Дүн	8508.1	10512.1	2004.0

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 13128.2 сая төгрөгийн бараа материал худалдан авч, хандив тусламжаар 429.2 сая, балансаас баланст 1221.6 сая төгрөгийн шилжүүлэн авч, нийт 14779.0 сая төгрөгөөр нэмэгдэж, балансаас баланст шилжүүлсэн 996.5 сая, акталсан 332.4 сая төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Бөмбөгөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2018 оноос хойш баригдсан спорт заалны барилгын ажлын санхүүжилтэд олгосон 110.0 сая төгрөгийг аймгийн ОНХС-ийн тайланд, 113.5 сая төгрөгийг сумын ОНХС-ын бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэсэн ба 2019 оны Бөмбөгөр сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дээрх санхүүжилтээс гадна аж ахуйн нэгж, байгууллагаас 2018 онд 70.0 сая, 2019 онд 40.0 сая төгрөг олгосон байхад санхүүгийн тайланд тусгаагүй зөрчил илэрсэнд хөрөнгийн өртгийг нэмэгдүүлж бүртгэх албан шаардлага хүргүүлсэн ба тус барилгын ажилд олгосон 333.5 сая төгрөгийн санхүүжилтийн ажлын гүйцэтгэлийг мэргэжлийн байгууллага, хөрөнгийн үнэлгээчнээр тогтоолгож, ажлыг гэрээнд заасан хугацаанд чанартай хийж гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.
- Төсөвт байгууллагууд хөрөнгөд бүртгэлтэй малын нас дэвшилтийн хөдөлгөөнийг бүртгээгүй, туслах аж ахуйн орлогыг дансанд бүрэн оруулаагүй, малын тоог А дансаар баталгаажуулах байдал хангалтгүй байна. Аудитаар мал амьтны бүртгэлтэй төсөвт байгууллагуудыг аймгийн Статистикийн хэлтсээс гаргуулан авсан бүртгэлтэй түүвэрлэн тулган шалгахад Эрдэнэцогт сумын ЗДТГ, Эрүүл мэндийн төв, Бөмбөгөр, Заг сумдын ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй мал статистикийн хэлтэст байгууллагын нэр дээр бүртгээгүй байна. Иймд цаашид санхүүгийн тайланд бүртгэлтэй малын нас дэвшилтийн орлого, зарлагыг холбогдох хууль, журмын дагуу зах зээлийн ханшаар үнэлж бүртгэн, оны эцэст малын тоог А дансаар баталгаажуулж, тооллогын бүртгэлд хавсарган баталгаажуулж аудитын байгууллагад ирүүлж байх зөвлөмжийг хүргүүлэв.

2.8.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 226502.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 242758.6 сая төгрөг болж 16255.9 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүнээс төсөвт байгууллагын үндсэн хөрөнгө 183.8 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт үндсэн хөрөнгийн 64.1 хувийг биет хөрөнгө, 35.9 хувийг биет бус хөрөнгө эзэлж байгаа ба биет бус хөрөнгийн эцсийн үлдэгдэл 9007.0 сая төгрөг болж 178.3 сая төгрөгөөр нэмэгдсэний 3.5 хувийг программ хангамж, 96.5 хувийг газар болон бусад биет бус хөрөнгө эзэлж байна.

**Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Хүснэгт 12. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Ангилал	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	165,597.4	178,666.7	13,069.3
Тээврийн хэрэгсэл	7,443.3	8,307.4	864.1
Машин тоног төхөөрөмж	17,283.0	18,483.9	1,200.9
Тавилга эд хогшил	7,590.5	8,239.2	648.7
Зам гүүрийн байгууламж	940.7	965.6	24.9
Батлан хамгаалахын тоног төхөөрөмж	4.9	0.0	-4.9
Түүх соёлын дурсгалт зүйл	949.4	963.7	14.3
Дуусаагүй барилга байгууламж	2,717.5	1,513.3	-1,204.2
Номын фонд	840.6	942.5	101.9
Бусад үндсэн хөрөнгө	14,306.5	15,669.3	1,362.8
Программ хангамж	302.8	317.1	14.3
Бусад биет бус хөрөнгө	8,525.8	8,689.9	164.1
ДҮН	226,502.7	242,758.6	16,255.9

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр үндсэн хөрөнгө бэлтгэсэн 31373.7 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 20115.1 сая үнэ төлбөргүй хандиваар авсан 9497.0 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас баланст шилжүүлсэн 2099.7 сая, акталсан 4933.2 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд өмнөх онд 14 байгууллагын 2717.5 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэйгээс тайлант онд 6 байгууллага 1377.0 сая төгрөгийн дуусаагүй барилгыг ашиглалтад хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлж, оны эцэст 8 байгууллагын 1513.2 сая төгрөгийн хөрөнгө дуусаагүй үйлдвэрлэл дансанд үлдэгдлээр байна.

Аудитын илрүүлэлт:

- *Монгол Улсын Ерөнхий аудитораас тайлант хугацаанд хэрэгжүүлэх чиглэлийн дагуу төсөвт байгууллагуудын биет бус хөрөнгөд бүртгэлтэй программ, хангамжийн ашиглалтад хийсэн судалгаагаар архивын, монгол бичгийн, төрийн сангийн, дүн бүртгэлийн, вирусны гэх мэт программ ашиглалтгүй байхад данс бүртгэлээс хасаагүй байна. Иймд хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтгүй байгаа программ хангамжуудыг цаашид ашиглах боломжтой эсэхийг тодруулж, холбогдох арга хэмжээг авч ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.*
- *Шинэжинст, Бууцагаан сумын Эрүүл мэндийн төв, Бууцагаан, Бөмбөгөр сумын ЗДТГ, Баянхонгор сумын 2,3,11 дүгээр цэцэрлэг, "Хайрхан фарм" ХХК, "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ, жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй байна.байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1⁴-т заасантай нийцэхгүй тул албан шаардлагыг төсвийн шууд захирагч нарт хүргүүлсэн.*
- *Баянхонгор, Баянбулаг, Баян-Овоо, Бууцагаан, Баян-Өндөр, Бөмбөгөр сумын ЗДТГ зэрэг төсөвт байгууллагууд төсвийн хөрөнгөөр худалдан авсан суудлын автомашиныг байгууллагын нэр дээр шилжүүлээгүй байсан зөрчилд аудитаар албан шаардлага хүргүүлсэн байна.*
- *Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэг "Хонгорын мөнгөн үсэг" ХХК-тай гэрээ байгуулаагүй байхад 2019 оны 12 дугаар сард гадна модон тоглоомын үнэ 10.0 сая төгрөгийг шилжүүлж, тоглоомыг аваагүй байхад үндсэн хөрөнгөнд орлогоор бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2⁵, Сангийн сайдын 388 дугаар тушаалын 4 дүгээр зүйлийн 4.27⁶-т заасныг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоон барагдуулсан.*

2.8.7 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Нэгтгэсэн санхүүгийн тайланд урт хугацаат хөрөнгө оруулалт бүртгэгдээгүй байна.

⁴ жилийн санхүүгийн тайлан гараахын өмнө ... Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ"

⁵ 14.4 Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ. 14.4.2 Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага,

⁶ "Урьдчилж төлсөн төлбөрийг үүссэн тооцоо буюу төлсөн мөнгөн дүнгээр үнэлж бүртгэнэ"

2.8.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 8190.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 9827.0 сая төгрөг болж, 1636.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнээс богино хугацаат өр төлбөр 2960.4 сая төгрөг болж 1634.5 сая төгрөгөөр өссөн нь урьд оны хөрөнгө оруулалтын барьцаалж авсан хөрөнгийн үлдэгдэл, урьдчилж орсон орлого 30.4 сая төгрөгөөр буурсан ба нийт өр төлбөрийн 29.4 хувийг богино хугацаат өр төлбөр, 0.7 хувийг урьдчилж орсон орлого, 69.8 хувийг урт хугацаат өр төлбөр эзэлж байна.

Хүснэгт № 13. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр дүн	1,326.0	2,960.4	1634.4
Ажилчидтай холбогдсон өглөг	17.1	32.9	15.8
Бараа үйлчилгээний зардлын өглөг	904.5	934.3	29.8
Байгууллагад төлөх өглөг	187.6	1,894.2	1706.6
Хувь хүмүүст төлөх өглөг	103.8	15.8	-88.0
Татварын өглөг /ТӨҮГ/	6.2	7.3	1.1
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	0.5	-	-0.5
Дансны өглөг /ТӨҮГ/	6.9	6.9	0.0
Урьдчилж орсон орлого	99.4	68.9	-30.5
Урт хугацаат өр төлбөр дүн	6864.1	6866.6	2.5
Төгрөг	6013.6	6057.6	44.0
Хувь хүмүүсийн зээл	1010	1077.4	67.4
Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	5003.6	4980.2	-23.4
Гадаад валют	850.5	809	-41.5
Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	850.5	809.0	-41.5
Нийт өр төлбөрийн дүн	8190.1	9827.0	1636.9
<i>Үүнээс байгууллагын төрлөөр:</i>			
Богино хугацаат өр төлбөр дүн	1326.0	2960.4	1634.4
Төсөвт байгууллага	273.8	429.6	155.8
Төсөл/сан	120.4	1554.5	1434.1
ТӨҮГ болон ОНӨҮГ	931.8	976.3	44.5
Урт хугацаат өр төлбөр дүн	6864.1	6866.6	2.5
Төсөвт байгууллага	0.0	4818.2	4818.2
Төсөл/сан			0.0
ТӨҮГ болон ОНӨҮГ	6864.1	2048.4	-4815.7
Нийт өр төлбөрийн дүн	8190.1	9827.0	1636.9

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдлийн 14.6 хувь буюу 429.6 сая төгрөгийн өглөг нь төсөвт байгууллагын, 52.5 хувь буюу 1554.5 сая төгрөг нь барьцаа данс, 32.9 хувь буюу 976.3 сая төгрөг нь орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын өр төлбөр байна.

Барьцаа дансны 719.8 сая төгрөг нь хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлийн баталгаа, 834.7 сая төгрөг нь дуусаагүй ажлын санхүүжилт байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд богино хугацаат үнэт цаас, богино хугацаат зээл байхгүй ба оны эхэнд 3 ОНӨААН-тэй холбоотой 99.3 сая төгрөгийн урьдчилж орсон орлого бүртгэлтэй байснаас тайланд онд 46.6 сая төгрөгийн орлого барагдаж, нэмж 16.2 сая төгрөгийн урьдчилж орсон орлого бүртгэгдэж, оны эцэст 68.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Аудитын илрүүлэлт:

- Бөмбөгөр сумын ЗДТГ, “Хонгор шинэ агро” ОНӨААТҮГ-ийн санхүүгийн тайланд “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-д төлөх өглөг нь тооцоо нийлсэн акт байхгүйг аудитын явцад тус сангаас тодруулахад дээрх байгууллагатай гэрээ байгуулж, тоног төхөөрөмж олгосон боловч сангийн санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй байна. Иймд дээрх байгууллагуудын санхүүгийн тайланд тусгагдсан өглөгийг “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-тай тооцоо нийлж баталгаажуулах зөвлөмжийг хүргүүлэв.
- “Чандмань Баянхонгор” ХК-ийн татварын өглөгийн 119.5 сая төгрөгийг санхүүгийн нэгтгэсэн тайланд бусад байгууллагын нэр төрөл тайлагнасан алдааг аудитаар залруулав.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл оны эхэнд 6864.0 сая төгрөг байсан ба энэ нь 2017-2018 онд “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-д аймгийн ОНХС-аас ЖДҮ-ийг дэмжих зориулалтаар олгосон 1010.0 сая төгрөгийн эх үүсвэрийг бүртгэсэн ба тайлант аймгийн Засаг даргын 2019.04.25-ны өдрийн А/240 дүгээр захирамжаар жимс жимсгэнэ тариалах төслийн санхүүжилтэд ангилагдаагүй зардлаас 50.0 сая төгрөг олгосныг нэмж бүртгэсэн байна.

Аймгийн ОНХС-аас ЖДҮ-ийг дэмжих зорилгоор 2015-2016 онд олгосон зээлээс тайлант онд “Эрдэнэ-өвөр” 9.0 сая, “Баянхонгор контрактн” ХХК 8.4 сая төгрөгийн зээл төлснийг өглөгөөр бүртгэсэн байна.

Хүснэгт 14. Урт хугацаат өр төлбөр /сая төгрөг/

№	Байгууллага	2018.12.31-ний өдрийн үлдэгдэл	2019.12.31-ний өдрийн үлдэгдэл	Гэрээний огноо	Үндсэн төлбөр эхлэх хугацаа	Үндсэн төлбөр дуусах	Хугацаа хэтэрсэн /үндсэн/	хугацаа хэтэрсэн /хүү/	Үлдэгдэл	
									баталгаажуулсан	баталгаажуулаагүй
А.Азийн хөгжлийн банк										
1	“Чандмань Баянхонгор” ХК МОН-1847	94.4	89.3	2007.06.16	2012.05.30	2025.11.30	0.0	0.0	-	89.3
2	“Баянхонгор Эрчим хүч цахилгаан түгээх” ХХК МОН-1847	28.3	0.0	2006.04.19	2012.05.30	2025.11.30	-	-	0.0	0.0
3	“Чандмань Баянхонгор” ХК МОН-2301	4,818.2								
4	Орон нутгийн өмчийн газар	0.0	4,818.2							4,818.2
	дүн	4,940.8	4,907.5	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	4,907.5
Б.Дэлхийн банк										
1	“Баянхонгор Эрчим хүч цахилгаан түгээх” ХХК - МОН 3503	822.2	809.0	2006.11.27	2012.10.01	2036.10.01	183.9	0.0	809.0	0.0
	дүн	822.2	809.0	-	-	-	183.9	0.0	809.0	0.0
	Гадаад эх үүсвэрээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн дүн	5,763.0	5,716.5	-	-	-	183.9	0.0	809.0	4,907.5
В.Дотоодын эх үүсвэрээс авсан зээл										
	Чандмань-Баянхонгор ХК	91.0	72.8	43,237.0			0.0	0.0	72.8	
1	Хас банк	91.0	72.8	5/17/2018	6/25/2018	5/25/2023			72.8	0.0
	Үйлдвэржилт Хөгжлийн Корпораци ХХК	1,010.0	1,077.4		0.0	0.0	0.0	0.0	1,077.4	0.0
1	Төрийн сан /Орон нутгийн хөгжлийн сан/	560.0	560.0	2017.06.28					560.0	
2	Төрийн сан /Орон нутгийн хөгжлийн сан/	450.0	450.0	2018.04.20					450.0	
3	Төрийн сан /Ангилагдаагүй зардал-Жимс жимсгэнэ тариалах/	0.0	50.0	2,019.0					50.0	
4	Төрийн сан /ЖДҮ-ийн эргэн төлөлт/		17.4						17.4	
	Дотоодын эх үүсвэрээс авсан зээлийн дүн	1,101.0	1,150.2	43,237.0	0.0	0.0	0.0	0.0	1,150.2	0.0
	НИЙТ ДҮН	6,864.0	6,866.7	43,237.0	0.0	0.0	183.9	0.0	1,959.2	4,907.5

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

“Чандмань Баянхонгор” ХК-ийн 2012-2014 оны хооронд хэрэгжсэн Хот байгуулалтын салбарын МОН-2301 төсөлтэй холбоотой 4818.2 сая төгрөгийн зээлийг Сангийн яамнаас аймгийн ТЕЗ-ийн 2017 оны аудитлагдсан санхүүгийн нэгтгэсэн тайланд нотлох баримтгүйгээр нэмж залруулга хийж Засгийн газрын Э-тайланд бүртгэсэн ба тухайн урт хугацаат зээлийн өглөгийн нотлох баримтыг аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс удаа дараа шаардсан боловч ирүүлээгүй. Тухайн хөрөнгө нь санхүүгийн тайланд аймгийн ОНӨГ-т бүртгэлтэй байгаа тул аймгийн СТСХ, ОНӨГ, “Чандмань Баянхонгор” ХК-ийн удирдлагууд зөвшилцсөний үндсэн дээр тайлант онд 4818.2 сая төгрөгийн урт хугацаат зээлийн өглөгийг “Чандмань-Баянхонгор” ХК-аас аймгийн ОНӨГ-т шилжүүлэн бүртгэсэн байна. Цаашид тус өглөгийг барагдуулахад төсвийн ачаалал нэмэгдэх эрсдэл үүсэж болзошгүй тул аймгийн удирдлагууд Засгийн газарт зээлийг хэрхэн төлөх талаар зөвшилцөж ажиллах нь зүйтэй тул аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлэв.

Аудитын илрүүлэлт:

- *Аймгийн Засаг даргын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар “Чандмань Баянхонгор” ХК, “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн урт хугацаат үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, хугацаа хэтэрсэн зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг төлүүлэх талаар арга хэмжээ авах зөвлөмжийг аймгийн Засаг даргад өгсөн ч зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, “Баянхонгор Эрчим хүч” ЦТХХЗ Дэлхийн банкны МОН-3503 төслийн зээлээс 2012-2016 онуудад төлөх 183.9 сая төгрөгийг гэрээний дагуу төлөөгүй хугацаа хэтрүүлсэн байна.*
- *Аймгийн ОНХС-ийн санхүүгийн тайланд өмнөх онуудад ЖДҮ-ийг дэмжих зорилгоор олгосон зээлийн авлагын 475.9 сая төгрөг бүртгэлтэй ба аймгийн ИТХ-аас 2018 оны 11 дүгээр сард “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-д тус зээлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллахыг даалгасан тул тус зээлийн авлагыг “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-д шилжүүлэн бүртгэж, төлөгдөөгүй он удаан жил болсон зээлийг барагдуулах ажлыг эрчимжүүлэх зөвлөмжийг аудитаар хүргүүлж байна.*

2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 195281.3 сая, эцсийн үлдэгдэл 209538.4 сая төгрөг болж, 13703.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 15. Хуримтлагдсан үр дүн /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал	76,731.7	77,747.4	1,015.7	37.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	63,052.7	62,537.1	-515.5	29.8
Хуримтлагдсан үр дүн	56,050.7	56,050.7	-	26.7
Тайлант үеийн үр дүн	-	13,203.1	13,203.1	6.3
Дүн	195,835.1	209,538.4	13,703.3	100

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

- Засгийн газрын оруулсан капитал данс үндсэн хөрөнгийн өсөлт 1015.7 сая төгрөгөөр нэмэгдэж, дахин үнэлгээний үлдэгдэлтэй хөрөнгө данснаас хассанаас 515.5 сая төгрөгөөр дахин үнэлгээний нөөц данс буурсан ба тайлант үеийн үр дүн 13203.1 сая төгрөгийн байна.

- Бодлогын өөрчлөлт алдааны залруулга нь дахин үнэлэгдсэн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хассанаас 553.7 сая төгрөгийн өөрчлөлт орсон байна.

ТӨҮГ болон ОНӨҮГ хувьд эздийн өмч дансанд гарсан өөрчлөлт

Аймгийн Засаг даргын харьяаны орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот 7 байгууллагын санхүүгийн тайланд хуримтлагдсан үр дүн 392.7 сая төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

Хүснэгт 16. ОНӨААН-ийн хуримтлагдсан үр дүн /сая төгрөг/

№	ААН нэр	тоо	Орлого	Зарлага	2019 оны үр дүн	Өмнөх үеийн үр дүн	Хуримтлагдсан үр дүн
1	Баянхонгор Эрчим хүч ХХК	1	8829.6	8026.2	-409.7	-95.0	-504.6
2	Чандмань Баянхонгор ХК	1	1832.9	1695.0	137.8	344.6	482.4
3	Цэвэр хот ОНӨҮГГазар	1	642.7	643.0	-0.3	-269.8	-270.1
4	Баянхонгор хайрхан фарм ХХК	1	636.8	723.7	-90.9	73.3	-17.6
5	Нью майнинг ХХК	1	210.8	148.9	61.9	-8.6	53.3
6	Хонгор шинэ агро ОНӨААТҮГ	1	199.2	89.1	110.1	-8.2	101.9
7	Үйлдвэржилт хөгжлийн корпорац ХХК	1	118.0	319.7	-201.7	-88.5	-290.1
	ДҮН	7	12470.1	11645.7	-392.7	-52.1	-444.8

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 159 төсвийн байгууллага, 7 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 5 өрхийн эрүүл мэндийн төв, 41 тусгай сан, 21 төрийн сангийн санхүүгийн тайлан болон ангилагдаагүй зардал, замын сан, хяналтын барьцаа данс нийт 236 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 213 байгууллага аудитад хамрагдсанаас 129 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгч, 84 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 19 байгууллагад итгэл үзүүлсэн, 1 байгууллага аудитад хамрагдаагүй байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын харьяа “Баянхонгор Нью майнинг” ХХК нь 2018, 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүйгээс санхүүгийн тайланд аудит хийлгээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8⁷, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1⁸, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7⁹, 21 дүгээр зүйлийн 21.7¹⁰ дэх заалтыг зөрчсөн байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.03.04-ний өдрийн 18 дугаар тогтоолоор “Баянхонгор Нью майнинг” ХХК -ийг татан буулгах шийдвэр гарсны улмаас тус байгууллага нь аудитад хамрагдаагүй тухай албан бичгийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн даргын 2020.03.25-ны өдрийн 7/413 тоот албан бичгээр манай байгууллагад ирүүлсэн байна.

Иймд “Баянхонгор Нью майнинг” ХХК-ийн 2018, 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.5¹¹-т заасны дагуу байгууллагын тайланг нягтлан шалгаж, хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг аймгийн СТХС-ийн дарга, ерөнхий нягтлан бодогч, бүртгэлийн мэргэжилтэн нарт хүргүүлэв.

Мөн санхүүгийн нэгтгэсэн тайланд тайлант жилд ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд насан туршийн боловсролын төв, хувийн цэцэрлэг, сургууль, орон нутгийн нөөц хөрөнгө, улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөрөнгө оруулалт, байгаль хамгаалах сан, мал хамгаалах сан зэрэг 8 байгууллага, сангийн орлого, зарлагын гүйлгээг хамрагдаж нэгтгэгдсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 84 байгууллагыг түүвэрт хамруулж, 129 байгууллагад дүгнэлт хүргүүлснээс 108 байгууллагад “Зөрчилгүй”, 17 байгууллагад “Хязгаарлалттай”, 2 байгууллагад “Сөрөг”, 2 байгууллагад “Санал дүгнэлтээс татгалзсан” дүгнэлт өгсөн байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын харьяаны төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 8472.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 3324.4 сая төгрөгийн 61 алдааг залруулж, 957.9 сая төгрөгийн зөрчилд 146 төлбөрийн акт тогтоож, 2847.5 сая төгрөгийн зөрчилд 77 албан шаардлага хүргүүлж, 1343.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 226 зөвлөмж өгч, зөрчилтэй санал дүгнэлт авсан 20 албан тушаалтанд хариуцлага тооцох

⁷ Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүрүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүрүүлэх.

⁸ Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ. ⁹ тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах;

¹⁰ Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай болон Компанийн тухай хуульд заасан журмын дагуу жилийн эцсийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргана.

¹¹ “аж ахуйн нэгж, байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай шийдвэр гарсан, дампуурлын хэрэг үүсгэсэн үед... хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”

**Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтнуудад хүргүүлж, хэрэгжилтийг тооцож ажиллалаа.

Аймгийн Засаг даргын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн алдаа, зөрчлийг өмнөх онтой харьцуулбал санхүүгийн тайланд залруулсан алдаа 3086.9 сая, залруулагдаагүй алдаа 3994.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Он	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Залруулагдаагүй алдааны дүн	Санхүүгийн тайланд залруулсан алдааны дүн	Нийт алдааны дүн
2018	263.4	467	423.5	1153.9	237.5	1391.4
2019	957.9	2847.5	1343	5148.4	3324.4	8472.8
Өөрчлөлт	694.5	2380.5	919.5	3994.5	3086.9	7081.4

Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагын нийт зөрчлийг тоог өмнөх онтой харьцуулахад алдаа зөрчлийн дүн 7081.4 сая төгрөгөөр нэмэгдэж, зөрчилтэй санал дүгнэлт авсан байгууллагын тоо өмнөх оноос 16-аар нэмэгдсэн нь дараах зүйлсээс шалтгаалсан байна. Үүнд:

1. Ажлын байр нэмэгдсэн болон нягтлан бодогч нарын тогтворгүй байдлаас шалтгаалж, санхүүгийн ажилтнуудын дийлэнх нь шинээр томилогдсон.
2. Аймаг, сумын төрийн сангийн төлөөлөгч нар анхан шатны баримтын бүрдүүлэлт, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах гүйлгээнд хяналт тавьдаггүй, төсвийн хуваарьт өөрчлөлт орж, шинэчлэгдсэн хуваарь батлагдаагүй байхад мөн төсвийн захирагч, нягтлан бодогч нарын гарын үсэг зурагдаагүй баримтаар гүйлгээг хийдэг.
3. Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг мөрдөж ажилладаггүйгээс бараа материал дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй, үндсэн хөрөнгийн дансанд бараа материалыг бүртгэсэн зөрчил давтагдсан, өглөг, авлагыг дутуу тусгасан, бараа материалыг олгох тухай бүрд зарлагдаагүйгээс зарим байгууллагын бараа материалын үлдэгдэл тооллогын бүртгэлээс зөрүүтэй.
4. Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”-ын дагуу зарлагын гүйлгээг хянадаггүй.
5. Сангийн яамны Э-тайланд аудитлагдсан санхүүгийн тайланг оруулахдаа зөрүүтэй оруулсан байхад төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланг гаргахдаа сумын санхүүгийн албаны дарга хянаагүйгээс зөрүүтэй нэгтгэгддэг.
6. Төсөвт байгууллагуудад “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Acolous, Payroll программыг худалдан авч, хөрөнгөд бүртгэсэн хэдий ч зарим байгууллага цалингийн Payroll программыг ашигладаггүй, ашиглаж байгаа хэдий ч санхүүгийн тайланг бэлтгэн гаргах Acolous программтай холбоогүйгээс гараас бичилт хийснээс ажиллагсадтай холбоотой авлага, өглөг, цалингийн зардал зөрүүтэй илэрхийлэгдсэн.
7. Цалингийн Payroll программыг ашиглаж, хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээг хөрвүүлж, мэдээлэх бүрэн боломжтой байхад дийлэнх нягтлан бодогч үүнийг мэддэггүй, ашиглаж байгаа зарим нягтлан бодогч даатгуулагчийн кодыг зөрүүтэй мэдээлснээс авлага, өглөг зөрүүтэй мэдээлэгдсэн.
8. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар зарим байгууллага бараа материал дансанд хуралдааны хоолны зардал, сургалтын зардал гэх мэт нэг удаагийн шинж чанартай зардлыг бараа материалын дансанд орлогоор бүртгэж тайлагнасан.
9. Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийх комисст нягтлан бодогч, нярвыг томилдог, тооллогын үр дүнг хэлэлцэж, тооцоо бодсон актаар баталгаажуулдаггүй.

Иймд дээрх зөрчлүүдийг арилгах, давтан гаргахгүй байх, санхүүгийн ажилтнуудын санхүүгийн сахилга бат, ур чадвар, хариуцлагыг дээшлүүлэх талаар аймгийн СТСХ-ийн мэргэжилтнүүд анхаарч, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллах шаардлагатай байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд “Чандмань Баянхонгор” ХК нь татварын өглөгийн 119.5 сая төгрөгийг бусад зардлын өглөгөөр тайлагнасан байна.
- Сум хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээлийн 409.6 сая төгрөгийн авлагыг Өлзийт, Баацагаан сумд санхүүгийн нэгтгэсэн тайланд хувь хүмүүсээс авах авлагаар бүртгэснийг хувь хүмүүст олгосон зээлийн авлагаар залруулав.

Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

1. Баянхонгор аймгийн Засаг даргын харьяа “Баянхонгор Нью майнинг” ХХК нь 2018, 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүйгээс санхүүгийн тайланд аудит хийлгээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 , Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 , 21 дүгээр зүйлийн 21.7 дэх заалтыг зөрчсөн ба Үнэн зөв байдал, толилуулга бай тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.03.04-ний өдрийн 18 дугаар тогтоолоор татан буугдсан “Баянхонгор Нью майнинг” ХХК-ийн 2018, 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.5 -т заасны дагуу байгууллагын тайланг нягтлан шалгаж, хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг аймгийн СТХС-ийн дарга, ерөнхий нягтлан бодогч, бүртгэлийн мэргэжилтэн нарт хүргүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Богд, Жаргалант сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд итгэл үзүүлж, 18 төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд хийсэн аудитаар нийт 1003.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 798.5 сая төгрөгийн 10 алдааг залруулж, 2.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 158.9 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, аудитаар зөрчилтэй санал дүгнэлт авсан 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 44.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 24 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах зөрчлийг гаргасан 2 төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгч, сумдын Засаг дарга нарт хариуцлага тооцох албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлж, хэрэгжилтийг тооцож ажиллав.

№	Байгууллагын нэр	“Хязгаарлалттай” санал, дүгнэлтийн шалтгаан
1	Бууцагаан сумын Засаг дарга	Гүйцэтгэсэн горим сорилын дүнд төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 451.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрч дүгнэлт өгсөн 4 байгууллагаас ЭМТ, ЕБС-ийн санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, ЗДТГ-ын санхүүгийн тайланд “Сөрөг” санал дүгнэлт гаргасан, мөн сумын ИТХ-ын хуралдааны 2018 оны 11 дүгээр тогтоолоор ОНХС-гийн хөрөнгийн зардлыг өмнөх оны үлдэгдлээс 118.4 сая төгрөгөөр санхүүжихээр буюу зардлыг эх үүсвэрээс нь 1.8 сая төгрөгөөр илүү баталсан нь Төсвийн тухай хуулийн 15.4.1, 16.5.2, 57.3 дахь заалтуудыг зөрчиж санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
2	Бөмбөгөр сумын Засаг дарга	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 204.0 сая, сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 223.6 сая төгрөгийн алдаа илэрч, сумын ЗДТГ “Сөрөг”, ЭМТ нь “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан. Сумын Засаг дарга Н.Мөнхжаргал бичил уурхай эрхлэгчидтэй “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээ” байгуулж, гэрээний

**Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

3.1.11, 3.1.12 дахь заалтуудыг зөрчиж 27 иргэн, аж ахуйн нэгжээс 97.0 сая төгрөгийг авснаас 35,0 сая төгрөгийг Хөх толгойн 2 дугаар багийг эрчим хүчинд холбох, 40,0 сая төгрөгийг спорт заалны барилгын ажилд шийдвэрлүүлж олгосон зөрчил илэрсэн нь санхүүгийн тайлангийн толилуулгын Үнэн зөв байдал, Иж бүрэн байх, Тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Хүснэгт 17. "Хязгаарлалттай" санал дүгнэлт авсан төсвийн төвлөрүүлэн захирагч
Эх сурвалж: ТШЗ-ийн аудитын тайлан, аудитын гэрчилгээ*

Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн байгууллагаас 17 байгууллагад итгэл үзүүлж, 39 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 103 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгснөөс 86 байгууллагад "Зөрчилгүй", 15 байгууллагад "Хязгаарлалттай", 2 байгууллагад "Сөрөг" дүгнэлт өгсөн.

Хүснэгт 18. "Хязгаарлалттай" санал дүгнэлт авсан төсвийн төвлөрүүлэн захирагч

Байгууллагын нэр	Санал дүгнэлтийг хязгаарласан шалтгаан
Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургууль	Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн, дотуур байрны хүүхдийн ирцэд дотуур байранд байхгүй, гарсан хүүхдүүдийг бүртгэж, зардлаар тайлагнасан, аудитын явцад үнэн зөв мэдээлэл өгөөгүй, тэтгэвэрт гарсан багш, ажиллагсдыг ажиллуулахдаа хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй, цалингийн шатлалаар цалинжуулж, нэмэгдэл хөлс олгосон, батлагдсан орон тоог хэтрүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 21.1 сая төгрөгийн цалинг олгож, зардал хооронд гүйлгэн зарцуулсан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.3 дахь заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын Тохиолдсон байх, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэг	2019 оны эцэст цалингийн зардлыг тодотгосон байхад 4906,1 мянган төгрөгийн өглөгтэй гарч төсвийг хэтрүүлсэн, тухайн тайлант хугацааны жилийн эцсийн тооллогын бүртгэл баталгаажуулах санхүүгийн тайланд тусгасан нь бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдлийн үнэн зөв баталгаажуулах боломжгүй, үндсэн хөрөнгө, бараа материалыг орлого авахдаа буруу ангилж бүртгэсэн, 10,0 сая төгрөгийн өртөг бүхий тоглоомыг хүлээж аваагүй байхад хөрөнгөнд орлого авсан зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн толилуулгын Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
Баянхонгор сумын 11 дүгээр цэцэрлэг	Няравын хүнсний тайлан, хоолны цэс болон зарлагын баримтыг засварласнаас хоолны норматив зардлыг 3279,8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, тээвэр шатахуун болон эм боох бараа материалын няравын тайлан үнэн зөв гаргаагүйгээс 3251,6 мянган төгрөгийн зөрүүтэй тайлан гаргасан, жилийн эцсийн тооллогын бүртгэл нь анхан шатны баримтын бүрдлийн шаардлага хангахгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн толилуулгын Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
Баянхонгор сумын 2 дугаар цэцэрлэг	Алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн, тооллого хийсэн боловч, нягтлан бодогч тооцоог бодож акт үйлдээгүйгээс 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн бараа материалын тодруулгын дүн няравын бараа материалын дүнгээс нийт 24,6 сая төгрөгийн зөрүүтэй байгаагаас санхүүгийн тайлан үнэн зөв эсэхийг нотлох боломжгүй байна. энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн толилуулгын Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Түүх угсаатны зүйн Музей	Аймгийн ИТХ, ЗДТГ-аас Орон нутгийн музейн үзмэрийн хамгаалалт хийлгэхээр 2200,0 мянган төгрөг олгосныг зориулалт бусаар зарцуулсан, Музейн үзмэрийг орлого авах тушаал гаргахдаа үнийн дүнг зөрүүтэй гаргасан, нягтлан бодогч 3 үзмэрийг орлогод дутуу бүртгэсэн, өмнөх оны аудитаар буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр тогтоосон актын төлбөр 1062,3 мянган төгрөгийг төсвөөс төлсөн. Төсвөөс 819.6 мянган төгрөгөөр урилга, цаасан тор хийлгэж байгууллагын ой тэмдэглэх арга хэмжээнд зарцуулсан, мөн хүчин төгөлдөр бус гэрээ үндэслэн 2900,0 мянган төгрөгийг шилжүүлж аудитын явцад нөхөж бичсэн нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 20.2.6 дахь заалт, ЗГ-ын 2014 оны "Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээ"-ний тухай 147 дугаар тогтоолын 4-дэх заалтуудыг зөрчиж, санхүүгийн тайлангийн толилуулгын Үнэн зөв, Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
Хүүхдийн Тэмүжин театр	Батлагдсан орон тоо 20 байхаас 26 орон тойгоор ажилласан ба Аймгийн Засаг даргын 2019.12.26-ны өдрийн А/625 тоот захирамжаар цалингийн зардалд 13397,4 мянган төгрөгийн төсвийг нэмж тодотгосон байхад НДШ 4983,2 мянган төгрөгийн өглөгтэй гарч батлагдсан төсвийг хэтрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалтуудыг зөрчсөн, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал	Төсвийн зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл дутуу, шатахууны замын хуудсыг бүрэн бичээгүй, нярвын тайлан гаргалт хангалтгүй, тайлангаархи материалын орлого зарлагыг хүлээн авсан, өгсөн гарын үсэггүй зэрэг нь тухайн бараа материалын орлого, зарлага үнэн зөв эсэхийг нотлох боломжгүй ИТХ-ын төлөөлөгч нарын тойрогтоо ажиллах зардлын зарцуулалтын тайланг бүрэн аваагүй, ИТХ-ын хуралдааны 8778,4 мянган төгрөгийн зарцуулалтыг тушаал шийдвэр гаргаагүй, Өмнөх оны зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, тайлант онд худалдан авсан Соёрхол тэмдэг Хүндэтгэлийг орлого аваагүй, зарцуулалтын анхан шатны баримтууд бүрэн байхгүй байгаа нь нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хуулийг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн толилуулгын Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
Бууцагаан сумын ЭМТ	Үндсэн хөрөнгийн дансны тээврийн хэрэгсэл, бараа материалын дансны тусгай зориулалтын материал, бусад хангамжийн материалын дансны тооллогын материал байхгүй, бичиг хэргийн материал зөрүүтэй тоологдсон, Бараа үйлчилгээний бусад зардлаас 7500.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй шилжүүлж, шууд зардлаар бүртгэсэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1, 13.7 дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд Оршин байх, Эрх ба үүрэг, үнэн зөв гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
Бууцагаан сумын ЕБС	Тайлант онд "Их эффект" ХХК-ний 4150.0 мянга, "Ди Эн Констракшн" ХХК-д 9000.0 мянга, Баярнамд 7294.3 мянган төгрөгийг нэхэмжлэл, анхан шатны баримтгүйгээр гүйлгээ хийсэн, цалингийн зардлаас байгууллагын даргын 2019.12.13-ны өдрийн А/30 тоот тушаалаар 15000,0 мянган төгрөгийн түлшний хөнгөлөлт олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1, 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар "Эдийн засгийн ангилал батлах тухай" тушаалын "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах зааврыг баталсан 6 дугаар хавсралт"-ын "Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил" гэсэн төсвийн зарлагын ангиллыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн толилуулгын Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
Галуут сумын ЗДТГ	Нягтлан бодогч тайлант оны ажил гүйлгээний дансны бичилтийг хийхдээ Сангийн сайдын 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ыг мөрдөж ажиллаагүй, тайлант онд 725.8 мянган төгрөгийн шатахууны баримт баримтгүй, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 710.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, авлага, өглөгийг зөрүүтэй илэрхийлсэн, дуусаагүй барилгын дансанд бүртгэлтэй байсан 110000.0 мянган төгрөгийн хөрөнгийн НББ-ийн анхан шатны баримтгүй, барилга хүлээн авсан актгүй, шийдвэргүйгээр барилга байгууламжийн дансанд бүртгэсэн зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7, 14.4.2, 14.4.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн толилуулгын Оршин байх, Эрх ба үүрэг, үнэн зөв гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
Бөмбөгөр сумын ЭМТ	Байгууллагын 2019 оны төсөвт анх 408497.4 мянган төгрөг баталж, аймгийн Засаг даргын 2019.10.28-ны өдрийн А/560 тоот захирамжаар төсөвт зохицуулалт хийж, 14742.5 мянган төгрөгийг нэмж тодотгон 423239.9 мянган төгрөг болсон байхад төсвөөс Төрийн сан 433239.9 мянган төгрөгийн эрх нээж олгож, батлагдсан төсвийг 10000.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэснийг зөрчиж, санхүүгийн тайлангийн толилуулгын Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Баянбулаг сумын ЗДТГ	Алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн, тайлант онд Сум сурталчлах арга хэмжээг ААНБ-аар гүйцэтгүүлэхээр ЗДТГ-ын бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ худалдан авах зардлаас 10000,0 мянган төгрөгийг шилжүүлэхдээ хүчин төгөлдөр бус гэрээ байгуулан, анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийж, зарцуулалт тодорхойгүй, хэрэгжилтийг тооцоогүй зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 16.5.5, 6.4.1 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 дахь заалтууд зөрчиж, санхүүгийн тайлангийн толилуулгын Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
Шинэжинст сумын ЭМТ	Төсвийн зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад эмийн зардлаас 6,9 сая төгрөгийг шилжүүлсэн 3,9 сая төгрөгийг авлагаар тайлагнаагүй зардалд бүртгэсэн, 2019 оны жилийн эцсийн тооллогыг бүрэн хийж, үр дүнг хэлэлцэж, тооцоог бодож баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1 дэх заалтыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн толилуулгын Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
Баян-Овоо сумын ЗДТГ	Тайлант онд 37277,0 мянган төгрөгийн өвс тэжээлийг анхан шатны баримтгүй зарцуулж, 30235,0 мянган төгрөгийн өвс тэжээлийн борлуулалтын орлого тодорхойгүй санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4, 20.2.6 дахь заалтуудыг зөрчиж, санхүүгийн тайлангийн толилуулгын Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Эх сурвалж: Төсвийн шууд захирагч нарын аудитын тайлан, аудитын гэрчилгээ

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар 2 байгууллагад "Сөрөг" санад дүгнэлт хүргүүлж, төсвийн захирагч нарт хариуцлага тооцох саналыг холбогдох сумдын Засаг даргад хүргүүлж, биелэлтийг тооцож ажиллав.

Хүснэгт 19. "Сөрөг" санал дүгнэлт авсан байгууллага

№	Байгууллагын нэр	Сөрөг санал дүгнэлт өгсөн шалтгаан
1	Бууцагаан сумын ЗДТГ	Өмнөх оны буюу 2018 оны жилийн эцсийн санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, 2019 оны жилийн эцсийн тооллогын комисс томилогдсон тооллогын бүртгэлийг хийж, үр дүнг хэлэлцэж баталгаажуулаагүй, нягтлан бодогч нь нярвын тайланг сар бүр хянаж баталгаажуулдаагүйгээс нярвын тайлан, санхүүгийн тайлангийн бараа материалын орлого, зарлага зөрүүтэй, өр, авлагыг баталгаажуулаагүй, Зочид төлөөлөгч хүлээн авах зардалд батлагдсан 9,1 сая төгрөгийг зарцуулахдаа зохих журмын дагуу тушаал шийдвэрийг гаргахгүйгээр зарцуулсан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1, 18.2 дахь заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан төсвийн зарлагын эдийн ангиллыг ашиглах зааврыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн толилуулгын Үнэн зөв байх, Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
2	Бөмбөгөр сумын ЗДТГ	Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хуулийн дагуу зохион байгуулаагүйгээс зарим хөрөнгийг тоолоогүй, худалдан борлуулсны орлого дансанд орсон байхад малыг бүртгэлээс хасаагүй, малын тооны А данс байхгүй, нягтлан бодогч тооллогын бүртгэлийг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, борлуулсан өвсийг бараа материалаас зарлага гаргаж орлогыг дансанд бүрэн төвлөрүүлээгүй атлаа авлагаар бүртгээгүй, ЗДТГ нь 6007,5 мянган төгрөгийг байгууллагын харилцах дансаар дамжуулан бэлнээр гарган зарцуулж, холбогдох журам, зааврын дагуу кассын тайлан гаргаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2.1, 13.4, 14.4.2 дахь заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн толилуулгын Оршин байх, Тохиолдсон байх, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Эх сурвалж: Төсвийн шууд захирагч нарын аудитын тайлан, аудитын гэрчилгээ

Аудитаар нийт 4671.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 1747.9 сая төгрөгийн 44 алдааг залруулж, 277.3 сая төгрөгийн зөрчилд 115 төлбөрийн акт тогтоож, 1895.3 сая

төгрөгийн зөрчилд 62 албан шаардлага, алдаа, зөрчил гаргасан 16 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 750.5 сая төгрөгийн алдаа, зөрчилд 179 зөвлөмж өглөө.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Аймгийн Засаг даргын харьяа орон нутгийн өмчит 7 аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлж, 5 өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Зөрчилгүй 4, Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан 2 дүгнэлт өгсөн. Аймгийн Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 5 өрхийн эрүүл мэндийн төв төсөвт байгууллагаар нэгтгэгдэж байна.

Хүснэгт 20. "Дүгнэлт өгөхөөс татгалзсан" санал дүгнэлт авсан байгууллага

Эх сурвалж: Төсвийн шууд захирагч нарын аудитын тайлан, аудитын гэрчилгээ

Байгууллагын нэр	Дүгнэлт өгөхөөс татгалзсан шалтгаан
"Хайрхан фарм" ХХК	2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан 31,0 сая төгрөгийн авлагаас 17,0 сая төгрөг, 243,5 сая төгрөгийн өглөгөөс 203,0 сая төгрөгийг харилцагч бүрээр тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй санхүүгийн тайланд тусгасан, мөнгөн гүйлгээний тайланд Төрийн банкны харилцах дансны гүйлгээг бүрэн оруулаагүй, ХААН банкны харилцах дансаар хийсэн гүйлгээнээс орлогын 324,9 сая төгрөг, зарлагын 327,5 сая төгрөгийг дутуу тусгасан, үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл, үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллын журнал хөтлөөгүй, хөрөнгийн тооллого хийгээгүй, хөрөнгийн тооллого хийх талаар байгууллагын даргын тушаал гараагүй, сумдад ажиллаж байгаа эмийн сангуудын эмийг нэр төрөл бүрээр тооллого хийх комиссыг аймгийн Засаг даргын 2019.12.30-ны өдрийн А/686 тоот захирамжаар гаргасан боловч хэрэгжүүлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 13.1, 20.2.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2 дахь заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн толилуулгын "Оршин байх", "Иж бүрэн байх", "Үнэлгээ", "Үнэн зөв байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
"Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ	2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд өмнөх оны 235,0 сая төгрөгийн өглөгийг шийдвэргүйгээр санхүүгийн тайлангаас хассан, авлагыг 1,7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан, жилийн эцсийн хөрөнгийн тооллого явуулах тушаал гаргаагүй, тооллого хийгдээгүй мөн 32,2 сая төгрөгийн авлагыг харилцагч бүрээр тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, кассын тайлан гаргаагүй, бэлэн мөнгийг нярвын харилцах дансаар дамжуулан хийсэн ба 9,2 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, ажлын хөлсөнд олгосон 22,1 сая төгрөгөөс ХХОАТ суутган тооцоогүй олгосон, санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгээгүйгээс санхүүгийн тайлангийн нийт үзүүлэлтүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4,5,8, 20 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь заалтыг зөрчсөн нь АОУС-500 заасан батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 620.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 6.2 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 5.9 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 219.5 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, алдаа, зөрчил гаргасан 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 388.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд 16 зөвлөмж өгч, "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ, "Хайрхан фарм" ХХК-ийн дансны авлагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж шалгуулах албан бичгийг аймгийн Засаг даргад хүргүүлж ажиллав.

Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа орон нутгийн хөгжлийн сангийн 21, сум хөгжүүлэх сангийн 20, нийт 41 тусгай сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгав.

Аудитаар нийт 2177.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 772.1 сая төгрөгийн 5 алдааг залруулж, 672.6 сая төгрөгийн зөрчилд 29 төлбөрийн акт тогтоож, 573.7 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, 159.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж өглөө.

2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Орон нутгийн төсвөөс жил бүр төсөв баталж, нутгийн иргэдийн ЖДҮ-ийг дэмжих зорилгоор аймгийн ОНХС-аас олгосон 475.9 сая, “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-аар дамжуулан олгосон зээлийн 1060.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлүүд зээлийн гэрээнд заасан хугацаанд төлөгдөөгүйгээс 695.5 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн байгааг цаашид анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.2-т хамаарах орон нутгийн өмчит 182 байгууллага, орон нутгийн өмчит 5, нийт 287 төсвийн байгууллага, аж ахуйн нэгж шилэн дансны нэгдсэн портал системд бүрэн хамрагдаж, мэдээллийг байршуулж иржээ.

Баянхонгор аймгийн Засаг даргын харьяаны байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн 30.1 хувийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Хүснэгт 21. Шилэн дансанд байршуулсан мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Бүтэн жил	13	13	11	2	1
2	Хагас жил	3	3	3		
3	Улирал бүр	2	8	6	2	
4	Сар бүр	5	60	52	8	
5	Тухай бүр	6	72	36	35	
	Нийт	29	156	108	47	1

Баянхонгор аймгийн Засаг дарга нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд худалдан авах ажиллагаанд хийсэн тайлан дүгнэлт, бусад шалгалтын дүн, худалдан авах ажиллагааны тайлан, хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт гэх мэт мэдээллүүдийг хуулийн хугацаанд байршуулсан байна. Харин Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл гэх мэт 47 мэдээллийг хугацаа хоцроож байршуулж, Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг байршуулаагүй байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2¹²-т заасан бүрэн эрхийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг улирлаар шалгаж, нийт 4 удаа хяналт тавьж ажилласан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт, албан шаардлага өгөөгүй байна.

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг заасан хугацаанд гаргаж ирүүлсэн ба 4 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан хэдий ч зөвлөмжийн мөрөөр хийж хэрэгжүүлсэн ажлын үр дүнд ахиц гараагүй, өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийн тоо нэмэгдсэн, алдаа зөрчил давтагдсан зэргээс шалтгаалж зөвлөмжийн хэрэгжилт 85 хувьтай байна.

Хүснэгт 22. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

¹² “Шилэн дансны тухай хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу ТЕЗ хэрэгжүүлнэ”

**Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

№	Өгсөн зөвлөмж	Байгууллагаас ирүүлсэн хариу	Аудитаар тооцсон биелэлт
1	Сум бүрд 2018 онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан сум хөгжүүлэх сангийн програмд мэдээллийг бүрэн оруулж, Монгол банкны зээлийн мэдээллийн санд мэдээллийг хүргүүлж ажиллах	Монгол банкт хамтран зээлдэгчийн мэдээллийг зээлийн мэдээллийн нэгдсэн санд оруулан ажиллах тухай мэдэгдлийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү Төрийн сангийн хэлтсийн даргын 2019.07.08-ны өдрийн 5/952 албан бичгээр аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн. Мөн Монгол банкны Баянхонгор аймаг дах салбарт, сумдын ИТХ, Засаг дарга нарт энэ тухай мэдээллийг 5/970, 5/969 албан бичгээр хүргүүлж ажилласан.	Сум хөгжүүлэх сангийн программыг бүх сум худалдан авч ашиглаж байгаа боловч Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газраас программ ашиглалтын сургалтыг зохион байгуулаагүй, арга зүйн зөвлөгөө дутмаг, сум хөгжүүлэх сан хариуцсан зарим мэргэжилтнүүд мэргэжлийн бус байгаа зэргээс шалтгаалж зээлдэгчийн мэдээллийг бүрэн оруулаагүй, тухайн онд тооцох авлагыг зөрүүтэй тусгасан, Монгол банкны зээлийн мэдээллийн санд зээлдэгчийн мэдээлэл ороогүй байна. Биелэлт 80 хувь.
2	"Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ-ыг аймгийн Засаг даргын дэргэдэх СХАА-аар шалгуулж цаашид тус аж ахуйн нэгж нь орон нутгийн төсөвт эрсдэл учруулах магадлалтай тул орон нутгийн өмчид байлгах эсэх талаар эрх бүхий байгууллагаар шийдвэр гаргуулах, бусад алдагдалтай ажиллаж байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, зорилтот түвшин, гэрээний биелэлтийг хангуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах	Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх дүгнэлт зөвлөмж гаргах удирдлагыг мэдээллээр хангаж ажиллах тухай 5/972 тоот албан бичгийг Санхүүгийн хяналт аудитын албанд 2019.07.18-ны өдөр хүргүүлсэн.	Аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанаас 2019 оны 09 дүгээр сард "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ-ын 2017, 2018 он, 2019 оны 3-р улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн боловч аудитын тайланг эцэслэж гаргаагүй байна. Биелэлт 100 хувь
3	Төсвийн шууд захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилган, аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг аудитын байгууллагад хугацаанд нь хүргүүлэх талаар хяналт тавьж ажиллах.	Бүх төсөвт байгууллагын дарга эрхлэгч, сумдын засаг дарга нарт аудитаас өгсөн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнгийн тайланг ирүүлэх тухай Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү Төрийн сангийн хэлтсийн даргын 05/885 тоот албан бичгийг 2019.06.24-нд хүргүүлсэн.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү Төрийн сангийн хэлтсийн даргын 05/885 тоот албан бичгийг 2019.06.24-нд төсөвт байгууллагуудад хүргүүлж ажилласан боловч зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна. Биелэлт 90 хувь
4	Сумдын санхүүгийн албаны дарга нарт төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланг хянаж, сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланг үнэн зөв тайлагнах мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлэх ажил зохион байгуулах.	Сумдын 20 санхүүгийн албаны дарга, 19 төсөв төрийн сангийн мэргэжилтнүүдээс түвшин тогтоох шалгалт авсан, аймгийн Төрийн аудитын газар, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Орон нутгийн өмчийн газартай хамтран сургалт зохион байгуулсан, аймгийн ИТХ-аар батлуулсан "Тунгалаг Санхүү" хөтөлбөр, 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу сургалт, зөвлөгөөн, туршлага судлах уулзалт зохион байгуулсан зэрэг ажлуудыг хийсэн.	Аймгийн Санхүү Төрийн сангийн хэлтсээс сургалт зөвлөгөөнийг зохион байгуулж байгаа боловч 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн тоо өмнөх оноос 7045.1 сая төгрөгөөр нэмэгдэж, зөрчилтэй санал дүгнэлт авсан байгууллагын тоо өмнөх оноос 16-аар нэмэгдсэн, төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд 798.5 сая төгрөгийн залруулга хийгдсэн, сургалтыг удаа дараа зохион байгуулж байгаа боловч зөрчил дутагдал арилахгүй байгаа нь тухайн ажилтнуудын мэдлэг, ур чадвар, хариуцлага хангалтгүй байна. Биелэлт 70%
БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ			85%

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Зөрчилгүй" дүгнэлт

Залруулагдаагүй 243.2 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 641.4 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул "Зөрчилгүй" дүгнэлтийг өгч байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

2.14. Менежментийн захидал

Баянхонгор аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч Г.Батжаргал, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга С.Байгалмаа, төсвийн ерөнхий нягтлан бодогч Ц. Самбууням нар танаа

Баянхонгор аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:


1. Сумдын төсөвт байгууллагын төсвийн захирагч нарийн Төсвийн тухай хууль тогтоомж дүрэм журмын талаарх мэдлэгийг дээшлүүлэх болон санхүүгийн ажилтнуудыг чадваржуулах, ажлын байрны сургалтыг зохион байгуулж, мэргэжил, ур чадварын түвшин тогтоох шалгалт тогтмол авч, арга зүйгээр хангаж ажиллах.
2. Аймгийн ОНХС-ийн санхүүгийн тайланд бүртгэлтэй ЖДҮ-ийг дэмжих зорилгоор олгосон 475.9 сая төгрөгийн зээлийг барагдуулахыг аймгийн ИТХ-аас 2018 онд “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-д даалгасан шийдвэрт тулгуурлан тус зээлийн авлагыг “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-д шилжүүлэн бүртгэж, төлөгдөөгүй он удаан жил болсон зээлийг барагдуулах ажлыг эрчимжүүлэх.
3. Зээлийн батлан даалтын сантай аймгийн Засаг дарга 2017.04.26-ний өдөр байгуулсан 07 тоот гэрээний дагуу аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа боловч барьцаа хөрөнгө багатай, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжийн зээл авах боломжийг нэмэгдүүлж, Зээлийн батлан даалтын сантай хамтарч ажиллах.
4. Бөмбөгөр сумын спорт заалны барилгын ажлын санхүүжилтэд олгосон 333.5 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийг мэргэжлийн байгууллага, хөрөнгийн үнэлгээчнээр тогтоолгож дүгнэлт гаргуулах, тус ажлыг гэрээнд заасан хугацаанд чанартай хийж гүйцэтгэхэд хяналт тавьж ажиллах.
5. Өмнөх онуудад сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн дуусаагүй, санхүүгийн тайланд авлагаар тусгасан 211.8 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг гэрээнд заасан хугацаанд дуусгаж, хөрөнгийг орлогод авахад хяналт тавьж ажиллах.
6. Нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг тооцоо нийлж, шийдвэр гарган санхүүгийн тайланд авлага, өглөгөөр тусгаж байх.
7. Бөмбөгөр сумын ЗДТГ, “Хонгор шинэ агро” ОНӨААТҮГ-ийн санхүүгийн тайланд “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-д төлөх өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах.
8. Санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилтэй санал дүгнэлт авсан орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдэд илэрсэн зөрчлүүдийг хууль хяналтын байгууллагад нэн даруй шилжүүлж, буруутай этгээдийг тогтоож, авлага өглөгийг бүрэн барагдуулж, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг хэрэгжүүлэхэд хяналт тавьж ажиллах.
9. Хот байгуулалтын салбарын 2012-2014 оны хооронд хэрэгжсэн МОН-2301 төсөлтэй холбоотой “Чандмань Баянхонгор”ХК-аас аймгийн ОНӨГ-т шилжүүлэн бүртгэгдсэн 4818.2 сая төгрөгийн урт хугацаат зээлийг хэрхэн барагдуулах, хөнгөлүүлэх талаар аймгийн ИТХ, Засгийн газарт хандан, арга хэмжээ авхуулах асуудлыг тавих.
10. Сум хөгжүүлэх сангаас олгосон нийт зээлийн 42.6 хувь буюу 1672.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах ажлыг сумдын Засаг даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд оруулж, биелэлтийг тооцож ажиллах.
11. Санхүүгийн тайланд бүртгэлтэй малын нас дэвшилтийн орлого, зарлагыг холбогдох хууль, журмын дагуу зах зээлийн ханшаар үнэлж бүртгэн, оны эцэст малын тоог А дансаар баталгаажуулж, тооллогын бүртгэлд хавсарган баталгаажуулж аудитын байгууллагад ирүүлж байх.

12. Төсөвт байгууллагуудын биет бус хөрөнгөд бүртгэлтэй боловч ашиглалтгүй программ хангамжуудыг цаашид ашиглах боломжтой эсэхийг мэргэжлийн байгууллагаас тодруулж, холбогдох арга хэмжээг авч ажиллах.
13. Баянговь сумын төрийн сангийн арилжааны банкин дахь дансыг хаах хүсэлтийг хүргүүлж, хэрэгжилтийг тооцож ажиллах.

Зөвлөмжийн мөрөөр зохиосон ажил түүний хэрэгжилт үр дүнгийн тайланг, холбогдох баримтын хамт 2020 оны 09 дүгээр сарын 01-ны дотор хэрэгжсэн тухай бүрд нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



The image shows a handwritten signature in black ink over a pink official stamp. The stamp is rectangular and contains the following text: 'Өмнөд бүс', 'Төрийн сан', 'Арилжааны банк', 'Төрийн аудитын газар', 'Баянговь сум', '6417143544', and 'БҮА0067 9007423'. The signature is written in a cursive style and extends across the stamp and the text 'ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР' and 'Б.МӨНХБАТ'.

3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>19,622,525.37</u>	<u>26,068,867.50</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,952,664.17	7,843,861.73
311	Кассад байгаа бэлэн мөнгө	2,595.46	2,721.29
31110	Төгрөг	2,595.46	2,721.29
312	Банканд байгаа бэлэн мөнгө	4,950,068.71	7,841,140.45
3121	Төгрөг	4,950,068.71	7,841,140.45
31211	Төрийн сангийн харилцах	4,259,589.59	6,730,935.14
31213	Арилжааны банк дахь харилцах	690,479.11	1,110,205.30
33	АВЛАГА	5,902,039.87	7,497,353.07
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	28,546.54	21,350.56
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	105,786.50	110,423.61
33401	Дансны авлага /ТӨҮГ/	69.87	646.16
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	915.40	915.40
335	Бусад авлага	1,052,128.49	1,903,355.06
33510	Байгууллагаас авах авлага	623,045.19	1,525,507.31
33520	Хувь хүмүүсээс авах авлага	429,083.30	377,847.75
336	Зээлийн авлага	4,714,593.07	5,460,662.29
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	4,714,593.07	5,460,662.29
33612	Хувь хүмүүст олгосон зээл	4,714,593.07	5,460,662.29
34	УРЬДЧИЛГАА	259,674.70	215,478.94
3471	Урьдчилгаа тооцоо	259,674.70	215,478.94
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	249,274.85	204,382.37
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	9,000.00	9,000.00
34713	Цалингийн урьдчилгаа	1,399.85	2,096.57
35	БАРАА МАТЕРИАЛ	6,577,608.08	8,741,345.37
351	Түүхий эд материал	1,166,200.81	1,488,859.95
35110	Тусгай зориулалттай материал	1,155,427.76	1,435,234.03
35130	Эм боох материал	10,773.05	53,625.92
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	86,558.39	436,044.09
35300	Бэлэн бүтээгдэхүүн	38,194.45	29,422.58
354	Хангамжийн материал	5,030,608.57	6,528,313.22
35410	Бичиг хэргийн материал	160,889.76	202,648.99
35420	Аж ахуйн материал	2,921,650.03	3,182,240.08
35430	Сэлбэг хэрэгсэл	33,427.32	27,146.30
35440	Түлш, шатах тослох материал	50,270.19	51,337.01
35450	Барилгын засварын материал	37,833.69	133,540.79
35460	Хүнсний материал	68,773.75	112,671.33
35470	Бусад хангамжийн материал	1,757,763.83	2,818,728.71
35600	Мал амьтад	256,045.85	258,705.54
36	НӨӨЦИЙН БАРАА	1,930,538.55	1,770,828.38
36100	Барааны нөөц	764,584.05	21,285.00

**Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд
